



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН

ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ



2023 ОН



2023 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС




Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 9, Засгийн газрын тусгай сан 19, төсвийн шууд захирагч 821, Улс болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 97, нийт 947 байгууллага, сан, зардлын 2022 оны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитыг хийсэн.

Үүнээс 284 байгууллагад дүгнэлт гаргаж, 663 байгууллагыг түүвэрт хамруулсан.



“Өөрчлөлтгүй” санал дүгнэлт **240** байгууллага



“Хязгаарлалттай” санал дүгнэлт **43** байгууллага




“Сөрөг” санал дүгнэлт **1** байгууллага

Аудитаар нийт 752,491.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 624,103.3 сая төгрөгийн алдааг тухайн байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд залруулан бүртгэсэн. Харин залруулах боломжгүй 1,268.0 сая төгрөгийн зөрчилд 140 төлбөрийн акт тогтоож, 80,972.7 сая төгрөгийн 1497 албан шаардлага хүргүүлж, 270.0 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 45,877.0 сая төгрөгийн 1559 зөвлөмж өгсөн.

БИЕЛЭЛТ


ТӨЛБӨРИЙН АКТ

1,180.4 сая төгрөг




АЛБАН ШААРДЛАГА

63,325.7 сая төгрөг



ЗӨВЛӨМЖ

37,544.9 сая төгрөг





Нийслэлийн ТЭЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 226 байгууллагын санхүүгийн тайланг хамруулан аудит хийсэн. Үүнд:



Нийслэлийн ТЭЗ-ийн
санхүүгийн нэгтгэсэн тайлан;



Нийслэлийн 9 дүүргийн
ТЭЗ-ийн санхүүгийн
нэгтгэсэн тайлан;



Төсвийн шууд захирагчийн
дүгнэлт гаргасан 49
байгууллага;

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн
тайланд санхүүгийн тайлан
нэгтгүүлсэн 139 байгууллага,
сан;



**НИЙТ
226**

Орон нутгийн өмчит 28 аж
ахуйн нэгж;



Аудитаар нийслэл, 9 дүүргийн харьяа аудитын дүгнэлт авсан нийт 124 шалгагдагч байгууллагаас



“Өөрчлөлтгүй”

7 дүүргийн санхүүгийн
нэгтгэсэн тайлан, 96
шалгагдагч байгууллагын
санхүүгийн тайланд



“Хязгаарлалттай”


2 дүүрэг, 19 шалгагдагч
байгууллагын
санхүүгийн тайланд

Аудитаар нийт 602,085.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 554,445.3 сая төгрөгийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 582.7 сая төгрөгийн 66 төлбөрийн акт тогтоож, 21,585.9 сая төгрөгийн 130 албан шаардлага хүргүүлж, 270.0 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 25,201.6 сая төгрөгийн 434 зөвлөмж өгсөн.

БИЕЛЭЛТ


ТӨЛБӨРИЙН АКТ

570.0 сая төгрөг




АЛБАН ШААРДЛАГА

6,709.2 сая төгрөг



ЗӨВЛӨМЖ

22,754.4 сая төгрөг





Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт нийцлийн аудит



НИЙТ 275,515.3 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ



119,271.8 сая төгрөгийн зөрчилд **61 албан шаардлага**




156,243.5 сая төгрөгийн зөрчилд **294 зөвлөмж**

- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" заалтыг хэрэгжүүлээгүй 105,530.6 сая төгрөгийн 85 зөрчил - 38.4 хувийг (Замын хөгжлийн газар 78,927.9 сая),
- Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4.3."тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;" 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8."бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" заалтуудыг хэрэгжүүлээгүй 83,913.9 сая төгрөгийн 5 зөрчил - 30.5 хувийг (Нийслэлийн нийтийн тээврийн газар 77,370.9 сая),
- Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалтыг хэрэгжүүлээгүй 43,859.7 сая төгрөгийн 146 зөрчил-15.9 хувийг (Баянзүрх дүүрэг 20,345.9 сая) эзэлж байна.

БИЕЛЭЛТ


АЛБАН ШААРДЛАГА

118,170.2 сая төгрөг



ЗӨВЛӨМЖ

152,630.4 сая төгрөг





ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



НИЙТ 2,811.0 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ



78.5 сая төгрөгийн зөрчилд 22 төлбөрийн акт



2,274.8 сая төгрөгийн зөрчилд 66 албан шаардлага



457.7 сая төгрөгийн зөрчилд 27 зөвлөмж


- Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: 12.1.1.гар утасны зардал; 12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр; 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад” заалтуудыг хэрэгжүүлээгүй 360.5 сая төгрөг,
- Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ” заалтыг хэрэгжүүлээгүй 399.3 сая төгрөг,
- Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.4 “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, 14.5 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” заалтуудыг хэрэгжүүлээгүй 857.5 сая төгрөг,
- Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” заалтыг хэрэгжүүлээгүй 555.2 сая, 15.2 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана” заалтыг зөрчсөн 311.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Нийслэлийн хэмжээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд Нийслэлийн ЗД 2022 оны А/656, А/657 дугаар захирамжуудаар Нийслэлийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж нийслэл, дүүргийн засаг даргын орлогч 21, агентлаг, харьяа байгууллагын дэд дарга, орлогч дарга 24, Засгийн газрын 2021 оны 375 дугаар тогтоолын дагуу нийслэл дүүргийн ИТХ-ын ажлын албаны албан хаагч 384 нийт 429 орон тоог бууруулсан байна. Мөн Засгийн газрын 2021 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж нийслэлийн харьяа байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, нийслэлийн өмчид бүртгэлтэй нийт 131 албан тушаалтны суудлын автомашиныг Нийслэлийн Төр захиргааны авто баазад татан төвлөрүүлжээ.

БИЕЛЭЛТ


ТӨЛБӨРИЙН АКТ

72.5 сая төгрөг



АЛБАН ШААРДЛАГА

2,216.0 сая төгрөг



ЗӨВЛӨМЖ

457.7 сая төгрөг

